



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 407

Улаанбаатар хот

### 「Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 05/14462 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Зам, тээврийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Артурыг 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрөөс томилсугай.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Н.ГАНБОЛД